

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : **2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр**

Тендер шалгаруулалтын нэр: **Баянзүрх дүүргийн 13, 14, 26 дугаар хороодын нутаг дэвсгэр “Туул дэд станц”, “Дүнжингарав дэд станц”-аас Дэчинравжайлин хийдийн урд тал хүртэл цахилгаан хангамжийн шугам сүлжээний нэвтрэх сувгийн зураг төсөл, барилга угсралтын ажил**

Тендер шалгаруулалтын дугаар: **НХААГ/202203323**

Нийслэлийн Орон сууцны бодлогын газар нь тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг **Баянзүрх дүүргийн 13, 14, 26 дугаар хороодын нутаг дэвсгэр “Туул дэд станц”, “Дүнжингарав дэд станц”-аас Дэчинравжайлин хийдийн урд тал хүртэл цахилгаан хангамжийн шугам сүлжээний нэвтрэх сувгийн зураг төсөл, барилга угсралтын ажил** гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендерийн баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд тендерийн баримт бичгийн үнийг төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 50,000 (тавин мянга) төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээснээс хойш 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн хамт Төсөвт өртөгийн үнийн дүнгийн 1%-тай тэнцэх үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Санхүүгийн чадавхын талаар шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах бусад баримт: Шаардана.

Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх.

Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: Сүүлийн 3 жил буюу 2019, 2020, 2021 онуудын дундаж төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр доод тал нь нэг удаа ажилласан байх. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2019, 2020, 2021

Тусгай зөвшөөрөл: Шаардана.

Тендерийг **2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим хэлбэрээр ирүүлэх** ба тендерийн нээлтийг **2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 10 цаг 30 минутад** зохион байгуулна.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **“Эрхгүй”**

Дотоодын давуу эрхийн зөрүү: **“Тооцно”**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг доорх хаягаар хүргүүлж болно.

**Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Ерөнхий сайд А.Амарын гудамж, Нийслэлийн өмчийн 1 дүгээр байр,
Соёлын төв өргөө, Г корпус, 11 давхар
Утас: 70110733**